

МОНГОЛ, ГЕРМАНЫ ХАРИЛЦАА: БОЛОМЖ БА ИРЭЭДҮЙ

У. Эрдэнэсанаа *

1. Түүхийн хуудас сөхөөс

Түүхээс үзвэл 1241 оны дөрөвдүгээр сард тэр үеийн Доод Силезийн гүн хоёрдугаар Хайнрих өрнө зүг цэрэглэн ирсэн монголчуудын довтолгооныг сөрөн тэмцэхээр зориг зүрх гарган Польш, Германы загалмайтны шилдэг цэргүүдийг манлайлан мордож Чингис хааны шадар жанжин Сүвээдэй баатрын цэргүүдтэй тулалдаад эдүгээгийн Польш улсын нутагт орших Легница хотын орчим болсон Валштаттын тулалдаанаар хиар цохигдон бут ниргүүлж Хайнрих гүнтэн өөрөө амь эрсэдсэн тухай дурдан тэмдэглэсэн байдаг бөгөөд Унгарыг эзлэн авах зорилготой явсан Монголын цэрэг Их хаан таалал болсон мэдээ авсан учир цааш цэрэглэн довтоллогүй эгсэн гэдэг.

Ийнхүү нэг л мэдэхэд Европт цөмрөн орж ирсэн монголчууд басхүү гэнэтхэн аян дайнаасаа эргэж нутгийн зүг зорьсон нь германчуудын хувьд нэг талаар завшаантай явдал болж монголчуудын довтолгоонд өртөж хүч тэнхээгээ шавхсан дорно чигт өөрсдөө аажмаар түрэн орж газар нутаг, нөлөөгөө тэлэхэд нь таатай нөхцөл бүрдүүлсэн гэлцэх нь ч буй.

Иймээс ч германчууд Европт хийсэн Монголын байлдан дагуулалтыг учир зүтгүй муучлан үзэх нь ховор, харин Германы нэрт монголч эрдэмтэн П.Рачневски зэрэг эрдэмтэн мэргэд “ард түмний хооронд эд өлгийн болон оюуны соёл харилцан нэвтрэлцэх саад бэрхшээлийг даван туулж улам түргэн нэвтрэх бололцоог буй болгон цар хүрээг нь тэлсэн” хэмээн Дорнод, Өрнөдийн соёл иргэншлийг холбоход чухал үүрэг гүйцэтгэсэн талаас нь авч үзэн нааштай үнэлсэн нь элбэг байдаг.

Аль арван гуравдугаар зуунд болоод өнгөрсөн дээрх явдлаас хойш Европт, түүний дотор Германд монголчуудын алдар дуулиан төдийлөн гарч байгаагүй боловч түүхээс ийнхүү улбаалсан германчуудын энэхүү бодитой гэмээр үнэлэлт, ойлголт монголчуудыг нэлээд ээвэргүү сэтгэлээр хүндэлж үзэх хандлага болон үлдсэн болов уу хэмээн бодогдох нь бий.

Монголчууд ч Европын улс гүрнүүд дотроос Германыг арай л илүү сонирхон харилцаа тогтоох хүсэл эрмэлзэлтэй байсан гэж үзэхэд хилсдэхгүй. 1911 онд Богд хаант Монгол улс байгуулагдсаны дараагаар гадаадын улс гүрнүүдтэй, түүний дотор өрнөдийн томоохон улсуудтай албан ёсны харилцаа тогтоох сонирхлоо Орос дахь албан ёсны төлөөлөгчдөөр нь дамжуулан

* МУИС, ОУХС-ийн докторант

илэрхийлж байсан тухай түүхэн мэдээ занги байдаг бөгөөд өрнөдийнхнөөс германчууд арай нааштай хандаж байсан гэх боловч харамсалтай нь энэ талаар тодорхой баримт сэлт хараахан олдохгүй байгаа юм.

Харин 1920-иод он гэхэд германчууд Монголыг нэлээд сонирхож германы “Юэнь Фунг трейдинг”, “Дорн”, “Симсон” зэрэг пүүсийн салбар, Герман-Монголын худалдааны нийгэмлэг Монголд ажиллаж байсан бөгөөд “Юэнь Фунг Трейдинг” пүүстэй худалдаа арилжааны хэлцэл хийх зарим ажилд Цэргийн яамны тэргүүн сайд, бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар зэрэг Монголын хувьсгалын удирдагчид, тэр үеийн дээгүүр албаны хүмүүс ч идэвхийлэн оролцож санаа тавьж байсан ажээ.

Түүнээс гадна “Мерседес Бенц” пүүс Монголтранстай хамтран өөрийн үйлдвэрийн машиныг Монголд зохицох эсэхийг туршихаар төлөөлөгчөө ирүүлж комисс гарган ажиллаж байсан, Берлин-Москва-Улаанбаатар-Бээжингийн чиглэлд нислэг хийх агаарын замыг судлахаар Люфтханзагийн төлөөлөгчид нисч байсан зэрэг баримт байдаг. Бас Улаанбаатарт тэр үед байгуулсан цахилгаан станц, тоосгоны завод зэргийн тоног төхөөрөмжийг Германаас авч байсан, манай Аж ахуйн явдлын яаманд герман сургагч, Цахилгаан гэрлийн хороо, Хэвлэлийн хороо, Цэмбэний завод, Монголтранс зэрэг байгууллагууд Германы мэргэжилтэн урьж ажиллуулж байжээ.

Энэ нь тухайн үедээ манай цорын ганц түнш бөгөөд холбоотон байсан хойд хөршийн анхаарлыг татаж тэр үед Монголд сууж байсан ЗХУ-ын Элчин сайд сэтгэл зовнихдоо герман мэргэжилтэнтэй өрсөлдөх буюу тэднээс давуу байх утгаар Зөвлөлтийн мэргэжилтний чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгаа тухай төвдөө сануулан бичиж байсан гэдэг.

Өрнөдийн соёл боловсролоос суралцах үүднээс Монголын охид хөвгүүдийг барууны орнууд руу илгээн суралцуулах шийд гаргахдаа Монголын тэр үеийн засгийн газар Германыг эн түрүүнд авч үзсэн нь тохиолдлын зүйл биш гэлтэй. Тухайлбал, 1926 оны 5 дугаар сард 13-17 насны 40 хүүхдийг Герман, Францад сургахаар илгээсэн бөгөөд тэдгээрийн 36 нь Германы Берлин, Лайпциг, Айзенах, Котбус, Райхенбах зэрэг хотуудад суралцаж байв. Тэд 1929 оны зун хүртэл Германд суралцаж байгаад буцаж иржээ. Энэ нь Германд фашизм үүсэн буй болсноос үүдэн улс төрийн таатай бус уур амьсгал бүрдсэн хийгээд манай улс үүнийг аюултай үзэгдэл хэмээн үзэх болсонтой холбоотой байлаа.

Мөн 1920-иод оны сүүлч, 30-аад оны эхээр манай Дотоодыг хамгаалах газраас германы “В. Дорн” пүүсийг үйл ажиллагаагаа зогсоож Монголын нутгаас гарч явахыг шаардах, Герман-Монголын худалдааны нийгэмлэгийн ажилтан Е.А.Давидсоныг гэнэт баривчлан хорих зэрэг арга хэмжээ авч Германы пүүс, байгууллагуудыг хавчин шахах алхмууд хийснээр Монголд үйл ажиллагааг нь зогсоосон байдаг. Нөгөөтэйгүүр 1931 оны 4 дүгээр сард Хөлөнбуйрын орчмоор тагнуулын нислэг хийсэн үл танигдах онгоцыг буудаж унагахад уг онгоц Германы Люфтханзагийн “Европ-Ази” хэмээх нийгэмлэгийнх байсан нь тогтоогдож, нисэгчид нь баривчлагдсан зэрэг явдал ч бас нөлөөлсөн болов уу. Үйл явдлын өрнөл ийнхүү таагүй тийшээ хандсан ч германчууд 1930-аад оны эхэн хүртэл манайтай бага боловч харилцаатай байсан өрнөдийн капиталист томоохон орон байлаа.

Гитлерийн фашистууд засгийн эрхэнд гарч ирсэн үеэс манай улс үүнд нэн таагүй хандах болж хориод онд Германд сурч байсан хүмүүсийг толгой дараалан сэрдэж тэднийг хэлмэгдүүлэн баривчилж, цагдан хорьж байсан юм. Улмаар

дэлхийн II дайн эхлэхэд манай улс өөрийн холбоотон ЗХУ-ын талд бат зогсож Гитлерийн Германд дайн зарлажээ. Энэхүү дайн фашизмын ялагдлаар дуусч Германыг ялсан гүрнүүдийн хяналтын бүсэд хуваан улмаар Германы газар нутаг дээр ХБНГУ, БНАГУ гэсэн хоёр улс байгуулагдахад манай улс социалист Германтай нь 1950 оны 4 дүгээр сарын 13-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд БНМАУ, БНАГУ-ын хооронд 1990 он буюу Германы хоёр улс нэгдэх хүртэл найрамдалт харилцаа, тал бүрийн өргөн хамтын ажиллагаа хөгжиж байв.

Харин ХБНГУ-тай бүр хожим буюу 1974 оны нэгдүгээр сарын 31-нд Германы талын санаачилгаар дипломат харилцаа тогтоосон бөгөөд хоёр талын харилцаа эрчимтэй хөгжөөгүй явж ирсэн нь тэр үеийн социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж асан орнууд Зүүн Германыг холбоотноо хэмээн үзэж түүний “гол дайсан” ХБНГУ-тай төдий л өргөн харилцахгүй байх чиг шугам баримталж байсантай холбоотой юм. Гэвч 1960-аад оны эхнээс хийж эхэлсэн Монгол, ХБНГУ-ын худалдааны эргэлт 1989 оны байдлаар 18,8 сая ам. долларт хүрч байсан нь өрнөдийн орнуудтай хийж байсан манай худалдаанд дээгүүрт тооцогдохуйц байсан хэрэг. Түүнчлэн хоёр орны хооронд 1986 онд Соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр, 1988 оноос Соёлын хамтын ажиллагааны Протокол байгуулан хэрэгжүүлж байлаа.

II. Монгол, Германы харилцааны шинэхэн үе ба өнөөгийн байдал

Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхийг тавьсан 1990 оны үйл явдлууд Германд улс үндэстнээ нэгтгэх түүхэн үйл явцтай давхацсан нь хоёр орны харилцааг энэхүү шинэ нөхцөл байдалд нийцүүлэн эрчимтэй хөгжүүлэх боломжийг буй болгосон юм.

Германы улс дахин нэгдсэний дараахан буюу 1990 оны 10 дугаар сард манай улс Боннд, ХБНГУ мөн оны 11 дүгээр сард Улаанбаатарт ЭСЯ-аа харилцан нээсэн бөгөөд Берлин хот нэгдсэн Германы нийслэл болсонтой холбогдуулан Монгол улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам 2000 оны 8 дугаар сараас Берлин хотноо шилжин байршиж ажиллах болсон билээ.

Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг нэгдсэн Герман улс бүр эхнээс нь тууштай дэмжиж ирсэн бөгөөд энэ чиг шугам нь стратегийн шинжтэй байгаа юм. Ерөөс Герман улс хөгжиж буй аль нэг улстай харилцаа хөгжүүлэх, ялангуяа хөгжлийн зориулалттай тусламж үзүүлэхдээ тухайн улсад:

1. хүний эрхийн асуудал ямар байдалтай байгаа;
2. улс төрийн аливаа асуудалд ард түмэн оролцож шийдэлцэх эрхээр хангагдсан эсэх;
3. хууль зүйн тогтолцоо, баталгаа ямар байгаа;
4. эдийн засагтаа зах зээлийн хууль, зарчмыг баримталдаг эсэх;
5. хөгжлийн ерөнхий хандлагын талаарх төрийн бодлогынх нь онцлог зэрэг үндсэн асуудлууд ямар байгааг харгалзан үздэг бөгөөд энэ утгаар нь авч үзвэл германчууд манай улстай хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллахад ямар нэгэн бодитой саад тогтор болох зүйл байгаагүй юм. Тухайлбал, нэгдсэн Герман улсаас Монголд айлчилсан хамгийн эхний дээгүүр зиндааны төлөөлөгчид нь Германы парламентын эдийн засгийн хамтын ажиллагааны байнгын хорооны төлөөлөгчид болон улмаар Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн

сайд К.Д.Шпрангер зэрэг хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл бүхий төлөөлөгчид байсан билээ.

Монголын талаас 1991 онд Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн, 1992 онд Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, 1993 онд Улсын Их хурлын дарга Н.Багабанди, 1995 онд Монгол улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат зэрэг өндөр, дээд зиндааны төлөөлөгчид ХБНГУ-д дараалан айлчилсан нь ХБНГУ-тай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд Монгол улс онцгой анхаарал тавьж байгаагийн илрэл байлаа. ХБНГУ-ын зүгээс ч 1991 онд Бундестагийн дэд Ерөнхийлөгч К.Д.Кроненберг, 1996 онд Холбооны дэд канцлер бөгөөд Гадаад хэргийн сайд К.Кинкель, 1999 онд ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч Р. Херцог зэрэг өндөр, дээд зиндааны зочид Монгол улсад морион ирсэн нь хоёр талын харилцааны гарамгай үйл явдлууд болсон төдийгүй ХБНГУ-ын зүгээс манай улсыг олон улсын тавцнаа дэмжих бодлогын нь илрэл байлаа.

Хоёр орны хооронд буй болсон энэхүү улс төрийн харилцааны таатай уур амьсгалыг эрх зүйн найдвартай үндсээр баталгаажуулах үүднээс 1995 онд Монгол улс, ХБНГУ-ын хоорондын харилцааны үндсийн тухай хамтарсан Тунхаглалд гарын үсэг зурсан бөгөөд Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Хэлэлцээр, Орлогын ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай Хэлэлцээр, Соёлын хамтын ажиллагааны тухай Хэлэлцээр, Агаарын харилцааны тухай Хэлэлцээр, Боловсрол, шинжлэх ухаан, судалгааны хамтын ажиллагааны тухай Хэлэлцээр, Залуучуудын бодлогын салбарт хамтран ажиллах тухай Протокол, Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Протокол зэрэг эдийн засаг, соёл, боловсрол, нийгмийн харилцааны өргөн салбарыг хамарсан 20 орчим чухал баримт бичгүүд шинээр буюу шинэчлэн байгуулаад амжилттай хэрэгжүүлж ирэв.

Нөгөөтэйгүүр манай улс ардчилсан төр, засгийн болон хэвлэл мэдээлэл, шүүхийн тогтолцоог боловсронгуй болгож бэхжүүлэх, хууль зүйн шинэтгэл хийх, боловсон хүчин давтан бэлтгэх, удирдлага, мэнежментийн арга барил эзэмшихдээ Германы туршлагыг нэлээд түшиж, тус дэмжлэгийг нь авч байгаа юм. ХБНГУ-ын Конрад Аденауэрийн, Фридрих Эбертийн, Ханс Зайделийн зэрэг улс төрийн томоохон сангууд Монголд улс төр, эдийн засаг, нийгмийн шинэтгэл хийх үйлсэд идэвхтэй хувь нэмэр оруулж, бодит тус дэмжлэг үзүүлсээр байгаа юм.

ХБНГУ-тай 1980-аад оны шувтаргаар Соёлын хэлэлцээр болон түүнийг хэрэгжүүлэх Протокол байгуулсны дараагаар буюу 1988-1990 онд Монголын түүх, угсаатны зүйн “Монголчууд” хэмээх үзэсгэлэнг Берлин, Хильдесхайм, Мюнхен зэрэг хотуудад гаргасан нь ХБНГУ-д зохиогдсон монголын соёлын анхны дорвитой арга хэмжээ байлаа. Улмаар Соёлын хэлэлцээрийн хүрээнд ХБНГУ-ын монголч эрдэмтэдтэй идэвхтэй хамтран ажиллах боломж нээгдэж Бонны Их сургуулийн монголч эрдэмтэд манай соёлын өв дурсгалыг судлах, хамгаалах, үйсэн дээрх бичгийг сэргээх, Монголын эртний нийслэл Хархорин хотод археологийн малтлага хийх зэрэг ажлыг амжилттай хийж буй бөгөөд Хархорины археологийн малтлагыг хоёр орны Ерөнхийлөгч нар ивээлдээ аван хэрэгжүүлж байна.

1989 оноос хойш манай ардын урлаг, циркийн уран бүтээлчид, хамтлагууд Германы зуучлагч агентуудын тусламжтайгаар аялан тоглох болсон бөгөөд тус оронд суурин ажиллаж буй Хөх Монгол, Бөртэ, Эгшиглэн зэрэг хамтлагууд Германд төдийгүй Европын зарим орнуудад ч амжилттай тоглоон үндэсний урлагаа сурталчилсаар байна. Мөн 1997 онд Бонн хотноо Монголын өдрүүдийг,

2001 онд Улаанбаатарт Бонны өдрүүдийг харилцан амжилттай зохион байгуулсан билээ.

2000 онд ХанOVER хотноо болсон ЭКСПО-2000 үзэсгэлэнгийн үеэр Монголын түүх, соёл, ардын урлагийн үзүүлбэр бүхий “Наадам” арга хэмжээг зохион байгуулсан нь Монголын уламжлалт соёл урлаг, нүүдлийн соёл иргэншлийн талаар олон орны зочин гийчинд таниулах, гадаадын жуулчдыг Монголд татах ажилд зохих үр дүнгээ өгсөн гэж үздэг.

Мөн Их Монгол Улсын 800 жилийн ойг угтан 2005, 2006 онуудад Германы Бонн, Мюнхен хотуудад “Чингис хаан ба түүний өв залгамжлагчид” сэдэвт томоохон үзэсгэлэн зохион байгуулж нээлтэд нь Монгол улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, ХБНГУ-ын хлбооны канцлер Г.Шредер нар албан ёсоор оролцсон юм.

Бүр 1920-иод оноос уламжлалтай Монгол Германы боловсролын салбарын хамтын ажиллагаа хуучин БНАГУ-ын үед ихээхэн гүнзгийрч 1956-1990 оны хооронд Монголын 25 мянга гаруй иргэн БНАГУ-ын их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудад суралцаж төгссөн буюу эрдмийн зэрэг цол хамгаалах зэргээр герман хэлийг эзэмшсэн бөгөөд 1990 он гэхэд Монголын 500 гаруй иргэн Германд Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр суралцаж байсныг Германы тал сургуулиа төгсгөл нь бүрэн санхүүжүүлсэн билээ. Түүнээс хойш Монголын иргэд ХБНГУ-д хувийн журмаар суралцах болсон бөгөөд Германы статистикийн 2006 оны мэдээгээр Монголын 1380 оюутан Германд суралцаж байв. Цаашдаа ч Германы хэл, соёлоос суралцах, ХБНГУ-д боловсрол эзэмших монголчуудын тоо болон сонирхол өсөх хандлага тогтвортой хадгалагдах магадлалтай байгаа бөгөөд үүнд Монголд үйл ажиллагаа явуулж буй Гёте институтын лавлах номын сан, Улаанбаатарт ажиллаж буй герман хэлний сургалттай улсын ба хувийн хэвшлийн дунд сургуулиуд, Германтай хамтран ажиллах зорилго, чиглэл бүхий Монгол-Германы чуулган, Герман-Монголын найрамдлын нийгэмлэг, Герман хэлний анд нөхдийн нийгэмлэг, Монгол-Германы бизнес форум, Германд сургууль төгсөгчдийн “Түүр” холбоо зэрэг 20 гаруй төрийн бус байгууллагууд зохих түлхэц өгч байгаа юм.

Монгол, Германы эдийн засгийн харилцааны салбарт хөгжлийн тусламжийн чиглэлтэй хамтын ажиллагаа давамгайлсан хэвээр байна. ХБНГУ энэ салбарт манайд туслахдаа 2000 он хүртэл

1. эдийн засгийн шинэтгэлийг дэмжих, хувийн хэвшлийг хөгжүүлж түүний байр суурийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх;

2. байгаль орчныг хамгаалах талаар хамтран ажиллаж туслах;

3. мэргэжилтэй боловсон хүчнээ давтан сургах, мэргэжил дээшлүүлэхэд нь туслах;

4. материаллаг болон нийгмийн салбарт дэд бүтцийг хөгжүүлэхэд туслах үндсэн чиглэл баримтлаж ирсэн бөгөөд 2001 оноос хойш эдийн засгийн шинэчлэл, зах зээлийн эдийн засгийн хөгжил болон байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, үүний дотор сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хамтран ажиллахад түлхүү анхааран ажиллаж байгаа юм.

ХБНГУ-аас манай улсын Засгийн газарт 1991-2005 онд нийтдээ 224 сая орчим еврогийн зээл, буцалтгүй тусламж олгосон бөгөөд 2006-2007 онд 35 сая америк долларын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгохоор тохирсон байна. Ер нь Герман улсаас тусламж авч буй дэлхийн улс орнуудын дотроос нэг

хүн амд ноогдох тусламжийн хэмжээгээр Монгол улс тэргүүлэх байруудын нэгэнд ордог ажээ.

ХБНГУ нь Монгол улсын хувьд Японы дараа хоёрдугаарт орж буй томоохон хандивлагч орон төдийгүй худалдаа, эдийн засгийн харилцааны Европ дахь гол түнш юм. 1990-ээд оноос идэвхжиж эхэлсэн худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин шинэ шинэ агуулгаар баяжин хөгжсөөр байна.

Энэхүү хамтын ажиллагаа Германы тэргүүний техник, технологийг Монголд нэвтрүүлэх, тус улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэн зохих үр дүнгээ өгсөөр байгаа юм. 2001 онд хоёр орны худалдааны эргэлт 32 сая орчим ам. доллар байсан бол 2003 онд 42,2 сая, 2005 онд 45,8 сая, 2006 онд 51,7 сая ам. доллар болон тус тус өссөн бөгөөд үүний дотор манай улсын экспортын хэмжээ 2001 онд 1,95 сая ам. доллар байснаа 2003 онд 4,6 сая, 2005 онд 12,4 сая, 2006 онд 10,7 сая ам. доллар тус тус хүрсэн байна.

2007 оны эхний байдлаар нийт 8,7 сая ам. долларын хөрөнгө оруулалт бүхий Германы хөрөнгө оруулалттай 90 гаруй компани, аж ахуйн нэгж Монгол улсад бүртгэлтэй байгаа ба гадаадын нийт хөрөнгө оруулалтын 0,7 орчим хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн асар их хүчин чадал бүхий Герман орны хөрөнгө оруулалтыг татах талаар манай улс төдий л сайн ажиллаж чадахгүй байгаагийн нэг илрэл гэж үзүүштэй. Монголын 10 гаруй компанийн суурин төлөөлөл Герман улсад бүртгэгдэн ажиллаж байгаа бөгөөд 1996 оноос эхлэн МИАТ компанийн онгоц Улаанбаатар-Берлин-Улаанбаатарын чиглэлээр тогтмол нислэг хийж байгаа нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны нөхцлийг цаашид сайжруулахад зохих үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Монголын эдийн засгийн боломж нэмэгдэхийн хэрээр хоёр орны бизнес, эдийн засгийн хүрээнийхэнд Германы талаас банк, санхүүгийн найдвартай тусламж үйлчилгээ үзүүлэх сонирхол, боломж бодитойгоор нэмэгдэх хандлага ажиглагдах болж байгаа юм. Тухайлбал, Германы Сэргээн босголтын банк, Баварын Ландесбанк зэрэг санхүү зээлийн байгууллагууд энэ чиглэлээр үйл ажиллагаагаа идэвхжүүлж байгаа ажээ.

III. Харилцааны цаашидын төлвийн талаарх зарим төсөөлөл

Ийнхүү Монгол, Германы харилцааны эдүгээгийн түвшин, түүний уур амьсгал, хоёр талаас энэхүү харилцааны ирээдүйг хэрхэн үзэж байгаа болон үүнд Монгол улсын гадаад бодлого, түүний Европын чиглэл, Герман улсын Азийн бодлогын үндсэн чиг шугам зэрэг бодит хүчин зүйлүүд таатай суурь дэвсгэр болох үндэслэлтэйг харгалзан үзвэл Монгол, Германы харилцаа цаашид өргөжин хөгжиж хамтын ажиллагааны найрсаг уур амьсгал батжин, түүний ойр дотно, итгэмжилсэн хандлага цаашид ч бэхжих үндэстэй юм.

Манай улс ХБНГУ-тай харилцахдаа Азийн бодлогынх нь үзэл баримтлал хийгээд ялангуяа түүний голлох 10 чиглэлийг Монголын язгуур эрх ашиг, амин сонирхол хийгээд хоёр талын харилцааны өнөөгийн түвшин, хэтийн ирээдүйтэй нягт холбон үзэх ёстой. Чингэж гэмээ нь бидний хүсэл сонирхол, Германы чиг бодлого, сонирхолтой хоёр талаасаа уулзан үр өгөөжөө өгөх бодит үндэс бүрдэнэ. Ийм учраас Монгол, Германы харилцааны цаашидын чиг баримжааг тогтоохдоо дараах хэдэн хүчин зүйлийг харгалзах учиртай болов уу.

1. Монгол улс хүн амын хувьд цөөн учир Германы хувьд сонирхол багатай, эдийн засгийн болон хэрэглээний багтаамжаар багахан зах зээл бүхий орон. Гэвч чухамдаа цөөхөн монголчуудын дотор хөдөлмөрийн насны хүний хувийн жин их юм.

Нөгөөтэйгүүр хүн амын дийлэнх олонх нь залуучууд бөгөөд боловсролын хувьд харьцангуй өндөр учир энэ нь аливаа улсын зүгээс манайтай хамтын ажиллагаа хөгжүүлэхэд харгалзан үзүүштэй нэг давуу тал мөн. Үүнээс гадна герман хэлээр ярьдаг 25 мянга гаруй монгол хүн байгаа төдийгүй гадаад, дотоодод сурч боловсорч байгаа залуучуудын дунд герман хэл сурч судлах эрмэлзэл хүчтэй хэвээр байгаа нь Германтай хоёр талын харилцаа хөгжүүлэх чухал потенциал хэмээн үнэлэгдэх учиртай.

Монгол, Германы харилцааны түүхэнд түвэгтэй, маргаантай асуудал байгаагүй, Монголын ард түмний дунд Герман орон, германчуудын талаарх ойлголт маш эерэг, нэр хүнд өндөр байдаг бөгөөд Монгол орон, монголчуудын талаарх германчуудын хандлага ч найрсаг, сайн байдаг.

Түүнчлэн монголчуудын хувьд ХБНГУ нь сонирхон жуулчилдаг орон төдийгүй одоогоор хамгийн олон монгол оюутан сурч буй улсын нэг бөгөөд герман хүнтэй гэр бүл болох, удаан хугацаагаар ажиллаж амьдрах зэргээр суурьшиж байгаа монголчуудын тоогоор Өрнөдийн орнууд дотор дээгүүр орж байна.

2. Харилцаанд нааштай нөлөөлөхүйц хүний хүчин зүйл хэмээн нэрлэж болох эдгээр зүйлээс гадна эдийн засаг, ШУТ-ийн хэмээн тодорхойлж болохуйц хүчин зүйлүүд ч бий. Юуны өмнө Герман улс нь эдийн засгийн хувьд хүчирхэг баян, аж үйлдвэр, техник технологи асар өндөр хөгжсөн бөгөөд гадаад худалдаагаараа дэлхийд гуравдугаар байранд ордог орны хувьд олон улсын тавцнаа улс төрийн жин нөлөөгөө цаашид нэмэгдүүлэх зорилго тавьж байгаа төдийгүй дэлхийн зах зээлд улам баттай байр суурь эзлэх, ялангуяа 90-ээд оны эхнээс хуучин социалист ихэнх орнууд нийгэм, улс төр, эдийн засгийн чиг баримжаагаа өөрчилж нээлттэй бодлого явуулан зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнтэй холбогдон гарч ирсэн шинэ нөхцөл байдал, буй болсон зах зээлд байр сууриа бэхжүүлэх эрмэлзэлтэй байдаг.

Ийм учраас өргөн уудам нутагтай, ОХУ, Хятад хоёрын дунд, Азийн төв хэсэгт байрладаг геополитикийн болон геоэдийн засгийн нэн чухал байршилтай төдийгүй байгалийн баялаг арвинтай, герман хэл бүхий боловсон хүчин ихтэй, Германы зүүн хэсэгтэй өргөн хамтран ажиллаж байсан тодорхой туршлага, уламжлалтай манай орныг ХБНГУ стратеги бодлогын үүднээс ч анхаарч сонирхсоор ирсэн юм. Нөгөөтэйгүүр Монголд орчин үеийн цахилгаан холбоо, тээвэр, дэд бүтцийн салбарууд болон жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хийгээд байгалийн баялгийг ашиглахад Герман улс хөрөнгө оруулалт хийх, техник технологио нэвтрүүлж манай зах зээлд баттай байр суурь эзэлж авах сонирхолтой байдаг төдийгүй Монголын эдийн засгийн өсөлт, эрдэс баялгаа эрчимтэй нээн ашиглах бодлого буй зэргээс үүдэн Германы засгийн газар, банк санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, ажил хэрэгч хүрээнийхний зүгээс Монголыг сонирхох явдал эрс нэмэгдэж байгаа талаар албаны хүмүүс их ярих болж байна.

3. Эдгээрээс гадна гадаад бодлого, аюулгүй байдал, энхийн хэмээн тодорхойлж болох хүчин зүйлүүд ч бий. 1990-ээд оны эхнээс манай улс ардчилал, шинэчлэлийн замыг тууштай сонгож улмаар нээлттэй, бие даасан гадаад бодлого

хэрэгжүүлж байгаа нь өрнөдийн гүрнүүд, түүний дотор нэгдсэн Герман улстай харилцаагаа эрс идэвхжүүлэх боломжийг нээсэн билээ. Нөгөөтэйгүүр хуучин БНАГУ-тай харилцаж байх үеийн хамтын ажиллагааны тодорхой өв уламжлал, найрсаг, итгэмжилсэн уур амьсгалыг нэгдсэн Герман улстай харилцахдаа уламжлан авч завсар гаргалгүй өвлүүлэн үргэлжлүүлснээр харилцааны улс төрийн суурь дэвсгэрийг эхнээс нь зөв тавихад анхаарч түүнийгээ хэрэгжүүлж чадсан явдал манай улсын хувьд чухал ач холбогдолтой болсон юм. Үүний үр дүнд Германы зүгээс Монгол улстай харилцаа хөгжүүлэх боломж, хэтийн төлвийг тандан судлах, стратеги бодлогынхоо шийдлийг гаргах үйл явц хэрэг дээрээ маш бага цаг хугацаа эзэлсэн буюу бараг шаардлагагүй байсан гэж үзэх ч үндэстэй.

Монгол улс хэдийгээр ХБНГУ-ын хувьд Ази, Номхон далайн бүс нутаг дахь сонирхол татсан гол түншүүдийн нь нэг биш боловч Германтай найрсаг, итгэмжилсэн харилцаатай, улс төрийн талаар найдвартай, эдийн засгийн хувьд бодит харилцаа хөгжүүлэх тодорхой нөөц бүхий орон байж чадах магадлалтай юм. Германы талаарх манай улсын бодлого, язгуур сонирхлын үндэс нь Европын Холбооны гол гүрэн, НАТО-гийн нөлөө бүхий орон ХБНГУ-ыг Европ дахь тэргүүн түншээ хэмээн үзэж түүнийг Орос, Хятад зэрэг их хөршүүд, Япон, АНУ зэрэг манай хувьд нэн чухал бөгөөд нөлөө бүхий түншүүдтэй тогтоосон харилцааг тэнцвэржүүлэх, эдгээр орнуудтай харилцах явцад гарч болзошгүй сөрөг үр дагаврыг саармагжуулахад чухал ач холбогдол бүхий нэгэн хүчин зүйл байлгаж Монгол улсын аюулгүй байдлыг улс төрийн аргаар хангах, баталгаажуулах бодлогын хүрээнд хамтран ажиллахад орших ёстой.

Нөгөөтэйгүүр Германтай сайн харилцаатай байх нь дэлхийн улс төр, эдийн засаг, цэргийн хүчний нэг том цөм болж байгаа Европын Холбоотой бүхий л салбарт хамтран ажиллах, тусламж дэмжлэг авч байх нэг ёсны утгвар нөхцөл, бодит баталгаа болох учиртай. Ийм ч учраас манай улс төр судлаачид, бодлого тодорхойлох болон хэрэгжүүлэх түвшний хүмүүс ХБНГУ-ыг Монголын гадаад бодлогын үзэл баримтлалд бий болон батжиж буй “гуравдахь хөршийн” талаарх ойлголт, томъёоллын түвшинд авч үзэн “онцгой, итгэмжилсэн” хэмээн Холбооны Ерөнхийлөгч Р.Херцог 1988 онд Монголд айлчлах үеэрээ тодорхойлсон Монгол, Германы харилцааг Монголын тал 21 дүгээр зуунд “иж бүрэн түншлэлийн” хэмжээнд хүргэн хөгжүүлэх эрмэлзэл сонирхолтой байгааг Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр 2002 онд ХБНГУ-д айлчлах үеэрээ илэрхийлсэн билээ.

Ном зүй

1. P.Ratchnevsky. *Genghis-Khan-His Life and legacy*. Oxford, Cambridge 1991.
2. U.Barkmann, L.Chaisandai. *Mongolisch-Deutsche Beziehungen. Vergangenheit-Gegenwart-Perspektiven*. Ulaanbaatar, 2004
3. Serge M.Wolff. *Mongolian Educational Venture in Western Europe (1926-1929)* Zentralasiatische Studien, Nr.5. Bonn, 1971
4. *Dokumente der 1. und 2. Konferenz des Mongolisch-Deutschen Forums*. KAS.Ulaanbaatar, 2004
5. Кай Мёллер. Монгол Улсын геостратегийн байршил: Бүс нутгийн ба олон улсын зарим хүчин зүйлүүд. МГЧ-ны 1,2 дугаар бага хурлын баримт бичгийн эмхэтгэл, Улаанбаатар. 2004
6. Фрийдхельм Ост. Шилжилтийн үеийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлууд. МГЧ-ны 1,2 дугаар бага хурлын баримт бичгийн эмхэтгэл, Улаанбаатар. 2004

7. Удо Д.Баркманн. Монгол Улсад гуравдах түнш хэрэгтэй юу?. Түүхэн сургамж ба орчин үе. Монгол, Германы хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хурлын материал, Улаанбаатар. 2004
8. Д.Уламбаяр. Монгол-Германы түрүү үеийн харилцаа. Олон Улс судлал сэтгүүл. УБ. 2001
9. Г.Алтай. Германы Монгол судлалын бүтээлүүд дахь түүхэн зарим баримтын тухай мэдээлэл. Герман: судалгаа, мэдээлэл сэтгүүл.№ 3. 2004.
10. Р.Жамц. Монгол-Германы харилцааг чанарын шинэ шатанд гаргах ирээдүй, боломж чиглэлүүд. Герман:судалгаа, мэдээлэл сэтгүүл.№ 2. 2003.
11. Л.Удвал. Монгол-Германы харилцаа 1990-ээд онд. МГЧ-ны 1, 2 дугаар бага хурлын баримт бичгийн эмхэтгэл, Улаанбаатар. 2004
12. Л.Удвал. Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны түүхэн эхлэл. Монгол, Германы хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хурлын материал, Улаанбаатар. 2004
13. Т.Галбаатар. Оюуны салбар дахь Монгол-Германы хамтын ажиллагаа. МГЧ-ны 1,2 дугаар бага хурлын баримт бичгийн эмхэтгэл, Улаанбаатар. 2004
14. Т.Галбаатар. Монгол, Германы харилцааны түүх, өнөөгийн байдал, хэтийн төлөв. Монгол- Германы хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хурлын материал, Улаанбаатар. 2004
15. Д.Сүхбаатар. Баримт бичгийн эмхэтгэл. Улаанбаатар, 2003